

**Аймгийн удирдах ажилтнуудын 2022 оны 10 дугаар сарын 03-ны
өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1	“Нэр өрх- Нэр ажлын байр” арга хэмжээний судалгааны мэдээллээ ХХҮГ-т яаралтай ирүүлэх	2022.10.10	Бүх байгууллага
2	Төрийн албан хаагчид Зөрчлийн хэрэгт ихээр холбогдож байна. Ихэнх тохиолдолд архидан согтуурсан үедээ зөрчил гаргасан байна. Прокурорын байгууллагаас анхааруулга ирүүлсэн бөгөөд төрийн албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар архидан согтуурах явдлыг таслан зогсоох. Байгууллагын болон салбарын хүрээнд соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тайланг ирүүлэх.	2022.10.10	Бүх байгууллага
3	Урлагийн наадамд оролцож байгаа байгууллагуудад хувцас, хэрэгслийн дэмжлэг үзүүлэх.	2022.10.24	Боржигин чуулга
4	Тарьж, ургуулж байгаа мод, бутны тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулж, дүн мэдээг актаар баталгаажуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газар хүргүүлэх	2022.10.17	Сумдын Засаг дарга нар
5	Татварын бааз суурийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүн гаргаж ажиллах	2022.12.05	Татварын хэлтэс